



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2024/213-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОН СУМЫН НЭГДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/213-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын цэцэрлэг нь 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 87.0 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 46,003.6 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалж нийт батлагдсан төсвийг 13.0 хувиар хэмнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар

тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>68,376,245.93</b>	<b>108,034,307.78</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>18,614,515.45</b>	<b>56,486,317.30</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>18,614,515.45</b>	<b>56,486,317.30</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>18,614,515.45</b>	<b>56,486,317.30</b>
31211	Төрийн сангийн харилцах	18,614,515.45	56,486,317.30
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>49,761,730.48</b>	<b>51,547,990.48</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>145,455.00</b>	<b>145,455.00</b>
35130	Эм боох материал	145,455.00	145,455.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>49,616,275.48</b>	<b>51,402,535.48</b>
35410	Бичиг хэргийн материал	4,085,500.00	4,531,000.00
35420	Аж ахуйн материал	43,848,095.48	44,348,095.48
35450	Барилгын засварын материал	-	313,500.00
35460	Хүнсний материал	568,130.00	1,095,390.00
35470	Бусад хангамжийн материал	1,114,550.00	1,114,550.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>257,400,230.23</b>	<b>237,718,729.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>257,400,230.23</b>	<b>237,718,729.95</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>247,051,605.34</b>	<b>227,765,938.38</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,220,700.00	241,220,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,486,216.80)	(43,107,771.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,574,989.43	38,674,989.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,429,366.04)	(24,383,975.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,236,821.00	11,236,821.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,833,217.17)	(7,139,424.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,360,195.00	17,360,195.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,592,300.08)	(6,095,595.84)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>10,348,624.89</b>	<b>9,952,791.57</b>
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(859,375.11)	(1,255,208.43)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,708,000.00	9,708,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>325,776,476.16</b>	<b>345,753,037.73</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>325,776,476.16</b>	<b>345,753,037.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>325,776,476.16</b>	<b>345,753,037.73</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	80,539,140.00	80,539,140.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	80,539,140.00	80,539,140.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>44,579,660.61</b>	<b>64,556,222.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(281,196,815.55)	44,579,660.61
51220	Тайлант үеийн үр дүн	325,776,476.16	19,976,561.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,657,675.55	200,657,675.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>325,776,476.16</b>	<b>345,753,037.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>668,002,543.66</b>	<b>425,635,147.78</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>337,950,731.45</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>337,950,731.45</b>	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	285,480,085.91	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	52,470,645.54	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>330,051,812.21</b>	<b>425,635,147.78</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>280,378,700.00</b>	<b>382,407,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,378,700.00	382,407,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,673,112.21</b>	<b>43,227,547.78</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,673,112.21	43,227,547.78
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>342,226,067.50</b>	<b>405,658,586.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>342,226,067.50</b>	<b>405,658,586.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>342,226,067.50</b>	<b>405,658,586.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>216,307,025.55</b>	<b>267,996,998.21</b>
210101	Үндсэн цалин	164,435,443.95	208,575,651.02
210102	Нэмэгдэл	46,305,632.10	50,298,103.49
210104	Урамшуулал	5,565,949.50	9,123,243.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,527,764.00</b>	<b>34,457,048.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,209,418.75	24,160,023.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,096,407.91	2,517,170.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,677,066.29	1,947,736.34
210204	Ажилгүйдлийн даатгал	413,233.77	472,417.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,131,637.28	5,359,701.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,977,057.21</b>	<b>38,144,947.78</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,349,153.21	5,068,527.75
210302	Түлш, халаалт	29,627,904.00	33,076,420.03
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,935,639.30</b>	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	273,790.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,558,349.30	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,684,915.76</b>	<b>29,836,140.00</b>
210502	Хоол, хүнс	24,684,915.76	29,836,140.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>496,100.00</b>	<b>3,382,600.00</b>
210604	Урсгал засвар	496,100.00	3,382,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>358,000.00</b>	<b>595,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	358,000.00	595,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,939,565.68</b>	<b>31,245,851.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,129,710.00	7,203,051.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,730,000.00	1,261,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,079,855.68	22,781,500.28
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>325,776,476.16</b>	<b>19,976,561.57</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>325,776,476.16</b>	<b>19,976,561.57</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>330,051,812.21</b>	<b>425,635,147.78</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>330,051,812.21</b>	<b>425,635,147.78</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>280,378,700.00</b>	<b>382,407,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,378,700.00	382,407,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,673,112.21</b>	<b>43,227,547.78</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,673,112.21	43,227,547.78
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>311,437,296.76</b>	<b>384,663,345.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>311,437,296.76</b>	<b>384,663,345.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>311,437,296.76</b>	<b>384,663,345.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>216,307,025.55</b>	<b>266,438,227.64</b>
210101	Үндсэн цалин	164,435,443.95	204,213,425.37
210102	Нэмэгдэл	46,305,632.10	53,101,558.57
210104	Урамшуулал	5,565,949.50	9,123,243.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,527,764.00</b>	<b>36,015,819.11</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,209,418.75	24,770,744.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,096,407.91	2,904,953.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,677,066.29	2,248,722.50
210204	Ажилгүйдлийн даатгал	413,233.77	548,229.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,131,637.28	5,543,169.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,977,057.21</b>	<b>38,144,947.78</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,349,153.21	5,068,527.75
210302	Түлш, халаалт	29,627,904.00	33,076,420.03
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,715,150.00</b>	<b>30,363,400.00</b>
210502	Хоол, хүнс	24,715,150.00	30,363,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>496,100.00</b>	<b>3,382,600.00</b>
210604	Урсгал засвар	496,100.00	3,382,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>358,000.00</b>	<b>595,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	358,000.00	595,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,056,200.00</b>	<b>9,723,351.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,806,200.00	7,934,351.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,789,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>18,614,515.45</b>	<b>40,971,801.85</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>3,100,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,100,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>3,100,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,100,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-	<b>(3,100,000.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>18,614,515.45</b>	<b>37,871,801.85</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,614,515.45
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,614,515.45	56,486,317.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	80,539,140.00	200,657,675.55	(281,196,815.55)	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	(281,196,815.55)	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	325,776,476.16	325,776,476.16
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	44,579,660.61	325,776,476.16
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	44,579,660.61	325,776,476.16
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	44,579,660.61	325,776,476.16
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	19,976,561.57	19,976,561.57
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,539,140.00	200,657,675.55	64,556,222.18	345,753,037.73

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>445,488,300.00</b>	<b>387,763,345.93</b>	<b>57,724,954.07</b>	<b>87.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>445,488,300.00</b>	<b>387,763,345.93</b>	<b>57,724,954.07</b>	<b>87.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>445,488,300.00</b>	<b>387,763,345.93</b>	<b>57,724,954.07</b>	<b>87.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>312,132,400.00</b>	<b>266,438,227.64</b>	<b>45,694,172.36</b>	<b>85.4</b>
210101	Үндсэн цалин	204,735,500.00	204,213,425.37	522,074.63	99.7
210102	Нэмэгдэл	96,045,800.00	53,101,558.57	42,944,241.43	55.3
210104	Урамшуулал	11,351,100.00	9,123,243.70	2,227,856.30	80.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,637,700.00</b>	<b>36,015,819.11</b>	<b>6,621,880.89</b>	<b>84.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,994,000.00	24,770,744.54	4,223,255.46	85.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,411,400.00	2,904,953.09	506,446.91	85.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,728,600.00	2,248,722.50	479,877.50	82.4
210204	Ажилгүйдлийн даатгал	682,300.00	548,229.96	134,070.04	80.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,821,400.00	5,543,169.02	1,278,230.98	81.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,341,400.00</b>	<b>38,144,947.78</b>	<b>1,196,452.22</b>	<b>97.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,413,100.00	5,068,527.75	344,572.25	93.6
210302	Түлш, халаалт	33,583,100.00	33,076,420.03	506,679.97	98.5
210303	Цэвэр, бохир ус	345,200.00	-	345,200.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,058,000.00</b>	<b>30,363,400.00</b>	<b>3,694,600.00</b>	<b>89.2</b>
210502	Хоол, хүнс	34,058,000.00	30,363,400.00	3,694,600.00	89.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,124,800.00</b>	<b>5,082,600.00</b>	<b>42,200.00</b>	<b>99.2</b>
210604	Урсгал засвар	5,124,800.00	5,082,600.00	42,200.00	99.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>596,300.00</b>	<b>595,000.00</b>	<b>1,300.00</b>	<b>99.8</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	596,300.00	595,000.00	1,300.00	99.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,597,700.00</b>	<b>11,123,351.40</b>	<b>474,348.60</b>	<b>95.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,808,700.00	9,334,351.40	474,348.60	95.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,000.00	1,789,000.00	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>445,488,300.00</b>	<b>425,635,147.78</b>	<b>19,853,152.22</b>	<b>95.5</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>382,407,600.00</b>	<b>382,407,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	382,407,600.00	382,407,600.00	-	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>44,466,200.00</b>	<b>43,227,547.78</b>	<b>1,238,652.22</b>	<b>97.2</b>
320001	Орон нутгийн төсвөөс	44,466,200.00	43,227,547.78	1,238,652.22	97.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>18,614,500.00</b>	<b>-</b>	<b>18,614,500.00</b>	<b>-</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	18,614,500.00	-	18,614,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,614,515.45	(18,614,515.45)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	56,486,317.30	(56,486,317.30)	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь “Хүүхдийг бүх талаар тэгш хөгжүүлэн эрүүл биетэй, саруул ухаантай сайн хүн болгох үндсийг тавих” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрхийг дээдэлж, ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэх,
- Сургуулийн өмнөх боловсролыг олон хэлбэр хувилбарт чиглэлээр чанартай олгож хүүхэд бүрийг бүх талаар хөгжүүлэх,
- Бага насны хүүхдийг ардын ёс заншилд суралцуулах,
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэх, сургуулийн өмнөх боловсролд оролцох олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан,
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1.“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, 2.“Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,976.5 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,614.5	56,486.3	37,871.8
Авлага	-	-	-
Бараа материал	49,761.8	51,548.0	1,786.2
Үндсэн хөрөнгө	257,400.2	237,718.7	(19,681.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>325,776.5</b>	<b>345,753.0</b>	<b>19,976.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	325,776.5	345,753.0	19,976.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>325,776.5</b>	<b>345,753.0</b>	<b>19,976.5</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 56,486.3 мянган төгрөг болж 37,871.8 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 51,548.0 мянган төгрөг болж 1,786.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 38,908.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд үйл ажиллагаанд 37,122.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 237,718.7 мянган төгрөг болж 19,681.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 22,781.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 295,273.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 41,296.2 мянган төгрөг нийт 336,569.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 17,071.1 мянган төгрөгөөр бууруулж 278,202.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн

санхүүжилтийг 41,296.2 мянган төгрөгөөр, нийт 319,498.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 122,819.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 401,022.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 3,170.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 44,466.2 мянган төгрөгөөр нийт 445,488.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 401,022.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 44,466.2 мянган төгрөг, нийт 445,488.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 387,763.3 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,238.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 56,486.3 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 387,763.3 мянган төгрөг буюу 87.0 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 3,694.6 мянган төгрөгөөр, хүүхдэд ээлтэй сургалтын орчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 0.3 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 68.5 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 46,003.6 мянган төгрөгөөр, явуулын багшийн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 1,666.1 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 5,053.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>401,022.1</b>	<b>344,535.8</b>	<b>56,486.3</b>	<b>85.9</b>
81605 - Эрүүл мэндийг дэмжих	894.5	894.5	-	100.0
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	34,058.0	30,363.4	3,694.6	89.2
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,027.8	2,027.5	0.3	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	894.5	826.0	68.5	92.3
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	252,762.6	206,759.0	46,003.6	81.8
81833- Явуулын багшийн үйлчилгээ	2,448.0	781.9	1,666.1	31.9
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	107,936.7	102,883.5	5,053.2	95.3
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>44,466.2</b>	<b>43,227.5</b>	<b>1,238.7</b>	<b>97.2</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	44,466.2	43,227.5	1,238.7	97.2
<b>ДҮН</b>	<b>445,488.3</b>	<b>387,763.3</b>	<b>57,725.0</b>	<b>87.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ цэцэрлэгийн хүүхдийн хоолонд 26,132.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 292,593.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,388.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Орхон сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас 154 мэдээлэл байршуулан 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 1 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт-1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл -1 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт – 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны тайлан – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудагд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр иргэн Ч.Пүрэвбат, Нансалмаа болон “Прогресс агро” ХХК, “Сүүн зам дейри” ХХК, “ЭПС арвижих” ХХК, “Соларрейн” ХХК-тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/48 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 709.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг үндэслэлгүйгээр олгосон зөрчилд төлбөрийн акт, шилэн дансны цахим цэсэд 7 мэдээлэл хугацаа хоцроож, 9 мэдээллийг огт мэдээлээгүй, төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 506.6 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	709.5	1	709.5	100.0
Албан шаардлага	2	506.6	2	506.6	100.0
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,216.1</b>	<b>3</b>	<b>1,216.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах **7,882.5** мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд бичиг хэргийн 70.8 мянган төгрөгийн, урсгал засварын 2,100.0 мянган төгрөгийн, нийт 2,170.8 мянган төгрөгийн зардлыг илүү тайлагнасан,
2. 5,590.4 мянган төгрөгийн ажил гүйлгээний дансны харьцааг буруу хийснээс шалтгаалан хөрөнгийн үлдэгдлүүд болон зардал буруу илэрхийлэгдсэн,
3. Байгууллагын эзэмшиж байгаа газарт 121.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар үр дүнгийн тайлангийн зардал илүү тайлагнагдсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **2,579.5** мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч албан шаардлага хүргүүлээ.

##### 5.1 Албан шаардлага

1. Бараа, ажил үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 1,276.9 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 1,302.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ыг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй	1	2,579.5			1	2,579.5							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,579.5</b>			<b>1</b>	<b>2,579.5</b>							

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим санд 5 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-							1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>								<b>1</b>			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1								1			
<b>Дүн</b>	<b>1</b>								<b>1</b>			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>								<b>2</b>			